



“БОГД БАНК ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН
ЖАМБАЛСҮРЭН ОВОГТОЙ НАРАНТУЯАГИЙН 2025 ОНЫ 3-Р УЛИРЛЫН АЖЛЫН ТАЙЛАН”

Миний бие Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн, Нэр дэвшүүлэх, үнэлгээ урамшууллын хороо болон Эрсдэлийн хорооны дарга, Аудитын хорооны гишүүнээр ажиллаж байна.

Тайлант хугацаанд компанийн тухай хууль, банкны тухай хууль, Богд банкны ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэсэн.

НЭГ. ТУЗ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хуралд оролцсон тоо: 19
Хэлэлцсэн асуудал: 42

2025 оны 3 дугаар улиралд Төлөөлөн удирдах зөвлөлийн 19 хуралд цахимаар болон танхимаар оролцож хурлаар хэлэлцсэн 42 асуудлаар саналаа хурлын тэмдэглэлд товч бичиж, хурлын шийдвэрт тусгуулан ажилласан.

ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ЭРСДЭЛИЙН ХОРОО

Нийт хуралдсан тоо: 1
Хэлэлцсэн асуудал: 5

2025 оны 3 дугаар улиралд Эрсдэлийн удирдлагын хороо 1 удаа хуралдаж 5 асуудал хэлэлцэж шийдвэрлэсэн.

2025 оны 3-р улирал				Санал өгсөн
1	2025.07.07	25/07	1. МУТС-ийн 2025 оны 2-р улирлын тайланг дүгнэх тухай 2. Авилга хээл хахуулийн бодлого батлах тухай 3. Мэдээллийн аюулгүй байдлын бодлого батлах тухай 4. Эрсдэлийн аппетит 2-р улирал 5. Богд банкны 2025 оны Тогтворжуулах төлөвлөгөөг шинэчлэн батлах тухай	Дэмжсэн

ГУРАВ. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ АУДИТЫН ХОРОО

Нийт хуралдсан тоо: 0
Хэлэлцсэн асуудал: 0

2025 оны 3 дугаар улиралд Аудитын хороо 0 удаа хуралдаж 0 асуудал хэлэлцэж шийдвэрлэсэн.

2025 оны 3-р улирал				Санал өгсөн

ДӨРӨВ. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ НЭР ДЭВШҮҮЛЭХ,
ҮНЭЛГЭЭ УРАМШУУЛЛЫН ХОРООНЫ ХОРОО

Нийт хуралдсан тоо: 1
Хэлэлцсэн асуудал: 1

2025 оны 3 дугаар улиралд Нэр дэвшүүлэх, үнэлгээ урамшууллын хороо 2 удаа хуралдаж 2 асуудал шийдвэрлэсэн.

2025 оны 3-р улирал				Санал өгсөн
1	2025.07.09	25/04	Гүйцэтгэх захирлын 2025 оны 2 дугаар улирлын ажлын гүйцэтгэлийг дүгнэх тухай	Дэмжсэн



**“БОГД БАНК ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН
ЖАМБАЛСҮРЭН ОВОГТОЙ НАРАНТУЯАГИЙН 2025 ОНЫ 3-Р УЛИРЛЫН АЖЛЫН ТАЙЛАН”**

Хорооны хурлуудад зарчмын зөрүүтэй санал гараагүй бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь компанийн эрх ашигт сөргөөр нөлөөлөөгүй, үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дүрэм, журамд нийцэж ажилласан.

ТАВ. СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ

Мөн хугацаанд Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалтын дагуу сонирхлын зөрчилтэй 1 удаагийн хэлцэлд оролцож өөрийн саналыг өгч, сонирхлын зөрчилтэй хэлцлийг тухайн асуудалд ашиг сонирхлын зөрчилгүй гишүүдийн 100 хувийн саналаар шийдвэрлэж ажилласан.

2025 оны 3-р улирал				Санал өгсөн
1	2025.09.25	25/89	Бодь цамхагт шугамын зээл олгох тухай	Дэмжсэн

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ ХУВЬД:

Богд банк ХК нь Монгол улсын Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон холбогдох Монголбанкны дүрэм журмын дагуу банкны засаглалыг хэрэгжүүлэн хангалттай сайн ажиллаж байна. Удирдлагын баг, ТУЗ-ийн гишүүд, Хувьцаа эзэмшигчдийн хооронд харилцааны үл ойлголцол байхгүй, банкны шийдвэр гаргалт нэг албан тушаалтны хэт төвлөрөлгүйгээр зохих журмын дагуу явагдаж байна. Миний бие ТУЗ хараат бус гишүүнээр ажиллах үед Компанийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.3 дахь заалтад заасан нөхцөл үүсээгүй болно.

Заавал мөрдөх ёстой аливаа хууль, дүрэм журмыг зөрчсөн болон харилцагч, хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт сөргөөр нөлөөлөхүйц шийдвэр, үйлдэл банкны үйл ажиллагаанд гараагүй болно.

Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох чөлөөлөх журмын 5 дугаар зүйлийн 5.1-т заасны дагуу 2025 оны 3 улирлын товч тайланг бэлдэн хүргүүлэв.

БОГД Банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн
2025.10.10

Ж.Нарантуяа